



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 27 өдөр

Дугаар А/305

Хэрлэн сум

Дэлгэрхаан суман дахь Зэвсэгт  
хүчний 232 дугаар ангид дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.21, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.8 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын Батлан хамгаалах зарим чиг үүргийг Хэнтий аймагт төлөөлөн 2024 онд хэрэгжүүлэх гэрээний 5.1 дэхь хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2 дугаар зүйлийн 2.1.4, дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэнтий аймгийн Дэлгэрхаан суман дахь Зэвсэгт хүчний 232 дугаар ангийн бие бүрэлдэхүүний албан үүргээ гүйцэтгэх нөхцөлийг хангахад зориулж 1,310,000 (нэг сая гурван зуун арван мянган) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дээрхи үйл ажиллагааны зардалд шаардагдах хөрөнгийг байгууллага, иргэдээс ирүүлсэн хүсэлтийг шийдвэрлэхэд зориулж, аймгийн Засаг даргын нөөц сангийн зардлаас олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ